

Банкны тогтвортой байдлын шинжилгээнд хөшүүргийн үзүүлэлтийг ашиглах нь

Ө. Гэрэлт-Од¹

Хураангуй

Банкны салбарын тогтвортой байдлыг үнэлэхэд санхүүгийн шинжилгээ голлох байр суурийг эзэлдэг. Дэлхийн улсууд үзүүлэлтүүдийг тооцоолох арга зүйн хувьд нийтлэг байдлаар Вазелийн зөвлөмжид санал болгосон санхүүгийн харьцааны үзүүлэлтүүдийг банкны салбарын тогтвортой байдлын хяналт үнэлгээнд ашиглахаас гадна банкны салбарын онцлогоос хамаарсан зарим нэг ялгаатай үзүүлэлтүүд болон босго утгыг засварлан хяналт үнэлгээг хийдэг байна. ОУ-ын түвшинд хийгдсэн банкны салбарын тогтвортой байдлын онолын судалгаа, туршлагыг судалсны үндсэн дээр МУ-ын банкуудын тогтвортой байдлын үзүүлэлтийг сайжруулах хэрэгцээ шаардлага, тооцох аргачлалыг боловсруулахыг зорьсон болно. Судалгааны үр дүнд хөшүүргийн үзүүлэлт нь банкны системийн тогтвортой байдлыг илэрхийлдэг эрсдэл, ашигт ажиллагаа, дампуурлын индексэд нөлөө бүхий үр дүнг үзүүлэх судалгааны ач холбогдолтой ба санхүүгийн тайлангаас тооцох боломжтой юм гэдгийг тодорхойлов.

Түлхүүр үгс: банкны тогтвортой байдал, тогтвортой байдлын шинжилгээ, хөрөнгийн хөшүүрэг

Оршил

МУ-ын банкны системийн санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээг хийх үзүүлэлтүүдийг оновчлох, өөрчлөлтийг хянах, нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийн дамжуулах суваг ба нөлөөллийг үнэлэн, гарах сөрөг үр дүнгээс банкны систем ба эдийн засгийг хамгаалах бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна. Монгол банк зохистой байдлын шалгуур үзүүлэлтийг Вазелийн үнэлгээний системд суурилан боловсруулан мөрдөж байгаа бөгөөд энэхүү үнэлгээний системийг 1988 оноос эхлэн дэлхийн банкууд нийтлэг байдлаар ашиглаж байна.

Банкны санхүүгийн тогтвортой байдлыг засаглалын тогтвортой байдлын асуудалтай нягт холбон үзэх болсон нь тогтвортой байдлын хяналт шинжилгээний шинэлэг арга хандлага юм. Вазел III-д банкны тогтвортой байдлыг засаглалын тогтвортой байдалтай холбон үнэлэх чиглэл тусгалаа олж, банкны санхүүгийн тогтвортой байдлыг эзний өмчийн тогтвортой байдлаар баталгаажуулах, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг ил тод болгох зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Манай улсын эдийн засгийн нөхцөл байдал, банк суурьтай санхүүгийн зах зээлийн тогтолцоог эрсдэлгүй удирдахад

¹ МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш.
E-mail: gereltod.u@gmail.com

банкны санхүүгийн тогтвортой байдал чухал бөгөөд өөрийн улсын онцлогт нийцүүлэн үнэлгээний системийг сайжруулан ашиглах шаардлагатай юм. Энэхүү зорилгоор банкуудын эх үүсвэр ба депозит хөрөнгийн зохистой байдлыг тогтоох замаар иргэдийн харилцах, хадгаламжийг эрсдэлээс хамгаалах асуудлыг судалсан болно. Судалгаанд банкны системийн тогтвортой байдлын үнэлгээ, зохицуулалтын олон улсын туршлагууд болон МУ-ын банкны системийн санхүүгийн үзүүлэлтийг (2001-2015 он, сараар) ашиглалаа.

Судалгаа

Бодлого зохицуулалтын байгууллагууд, үнэлгээний компаниуд банкны тогтвортой байдлын үнэлгээний арга зүйг сайжруулах чиглэлд судалгааг хийдэг ба тэдгээрийн дотор Төв банкуудын хийж буй судалгааны ажил томоохон байр суурийг эзэлдэг. Судалгааны ажлууд нь i) тогтвортой байдлыг хянах үнэлэх, ii) системийн тогтворгүй байдлаас хамаарсан сөрөг нөлөөллийг бууруулах зохицуулалтыг хэрэгжүүлэх, iii) илүү үр ашигтай санхүүгийн зуучлалын орчинг бүрдүүлэх гэсэн чиглэлээр² хийж байна. Үнэлгээ, шинжилгээний зорилго нь системийн хувьд эрсдэлийг удирдах, харилцагчийн хувьд сонголтыг оновчтой болоход туслахад чиглэгддэг.

Орчин үед банкны санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээг нэг банкнаас гадна системийн хүрээнд хийх болсон ба агуулгын хувьд санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн динамик хандлага хэр тогтвортой байгаа, дотоод ба гадаад хүчин зүйлсээс хамааран гарах өөрчлөлтөнд систем өөрөө хэр мэдрэг байна вэ, гарах сөрөг үр нөлөөнд банкны систем болон нийт эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх чиглэлээр хийгдэх болсон байна. Хэдийгээр банкны тогтвортой байдлын шинжилгээнд маргаан дагуулсан асуудлууд олон байдаг боловч түүний үр дүнд дараах ахиц гарсан гэж үздэг. Үүнд:

- Банкны тогтвортой байдал болон банкны системийн тогтвортой байдлын талаарх ойлголтууд нэгдсэн дүгнэлтэнд хүрч байгаа,
- Банкны системийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтийн сонголт, үнэлгээний арга аргачлал сайжирч, тэдгээрийг хянах зохицуулах бодлого хэрэгжүүлэх болсон,
- Үнэлгээг зөвхөн банкны системийн үзүүлэлтээр бус нийлмэл үзүүлэлтээр, тэдгээрийн харилцан үйлчлэлийг үнэлэх болсон,
- Системийн тогтвортой байдлын шинжилгээний үр дүн зөвхөн бодлого боловсруулах түвшний байгууллагуудын хэрэглээнд бус нийт санхүүгийн зах зээлд оролцогчдын хувьд ашиглагдах болсон зэргийг нэрлэж болно.

Банкны тогтвортой байдлын үнэлгээнд Төв банкуудын санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ голлох байх суурийг эзэлдэг ба хөрөнгийн төвлөрлийг сааруулах замаар банкны эрсдэлээс хамгаалах зохицуулалт бүхий хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдээс бүрддэг. Банкны хөрөнгийн хүрэлцээний зохицуулалтыг АНУ-д анх 1914³ оноос хэрэгжүүлж, банкны хадгаламж, өөрийн хөрөнгийн харьцааг ашиглах болсон байна. Уг үзүүлэлтийг одоо ч ашигладаг бөгөөд 8-20 хувь байх нь зохимжтой гэж үздэг

² Gadanecz, B., Jayaram, K. (2009). Measures of Financial Stability – A Review

³ Gadanecz, B., Jayaram, K. (2009). Measures of Financial Stability – A Review

байна. Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй байдал түүнийг зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх боломжийг олгохоос гадна эрсдэлийн хамгаалалт болдог. XX зууны дунд үеэс банкны өөрийн хөрөнгө зөвхөн хадгаламжтай зохистой харьцаатай байхаас гадна зээлийн эрсдэл, активын үнэ цэнийн бууралтаас хамгаалах хэрэгсэл гэж үзэх болсон. 1952 онд АНУ-ын Холбооны Нөөцийн Банк хөрөнгийн зохист харьцааг банкны зохицуулалтад ашиглах боломжийг тодорхойлох суурь судалгааг эхлүүлсэн ба 1956 оноос эхлэн эрсдэл даах чадварыг өөрийн хөрөнгөд харьцуулан тооцох аргачлалыг боловсруулж, активыг эрсдэлийн түвшингээр үндсэн 10 бүлэгт хуваан, тэдгээрийн эрсдэлийн түвшинг 0.5-100 хувиар тогтоож өөрийн хөрөнгийн зохист харьцааг тооцох болжээ. Банкууд хөрөнгө ба өр төлбөрийн зохистой харьцааг хангаж ажиллах нь тогтвортой байдлын үндэс гэж үздэг бөгөөд үзүүлэлтийг нэгтгэн үнэлэх замаар тогтвортой байдлыг: i) итгэж болох, ii) хангалттай, iii) дундаж, iv) хүлээн зөвшөөрөгдөх доод хязгаар, v) хангалтгүй гэж үнэлэх системийг ашиглаж эхэлсэн байна.

1988 онд Базелийн хорооноос⁴ банкуудын тогтвортой байдлыг хянах чиглэлээр гаргасан зөвлөмжийг ОУ-д Вазел I гэж нэрлэдэг ба банкны хувьд өөрийн хөрөнгийн эрсдэл даах чадвар, актив дахь эрсдэлтэй, идэвхтэй активтай харьцах харьцаа, дайчилсан хөрөнгө, нөөц, хөрөнгийн хамгаалагдсан байдал, орлого бүтээх чадвар, өөрийн хөрөнгө ба өр төлбөрийн харьцаа гэх мэт үзүүлэлтүүдийг өөрийн хөрөнгөтэй харьцуулан тооцохоор санал болгосон байдаг. Үнэлгээний үзүүлэлтүүдийг байнга сайжруулан, хөгжүүлж байгаа ба өнөөгийн байдлаар Вазел III⁵-ийг дэлхийн улсууд ашиглаж, Базелийн гэрээний үндсэн зарчмууд дэлхийн 100 гаруй улсын банкны хяналт шалгалтын системд нэвтрээд байгаа билээ.

Банкуудын тогтвортой байдлыг засаглалын тогтвортой байдалтай нягт холбон үнэлэх бодлого зохицуулалтын хандлага энэхүү системд тусгалаа олсон бөгөөд энэхүү зохицуулалтаар:

- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг өмнөх түвшинөөс 3-5 дахин өсгөсөн ба банкны санхүүгийн тогтвортой байдлыг эзний өмчийн тогтвортой байдлаар баталгаажуулах, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг ил тод болгох,
- Эрсдэлийг урьдчилан үнэлэх замаар эрсдэлийг удирдан тогтвортой байдлыг хангах гэсэн чиглэлд хэрэгжиж байгаа ба 2020 он гэхэд шат дараалалтайгаар аажмаар нэвтрүүлэх саналыг зөвлөмж болгосон байдаг.

Манай улсын банкны салбарын тэлэлт, хадгаламж буюу эх үүсвэрт суурилсан банкны хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа өнөө үед эх үүсвэр хадгаламжаас хэт хамааралтай байгаа ба энэ нь зээлийн хүү өндөр байх үндсэн шалтгааны нэг юм. Өөрийн хөрөнгө ба өр төлбөрийн (үндсэн депозит) зохистой харьцааг барьснаар банкууд хадгаламжаас гадна бусад өрийн хэрэгсэлүүдийг ашиглах хөшүүрэг болох сайн талтай.


2011 онд Базел III-ийг боловсруулахдаа үзүүлэлтүүдийн шалгуур, тооцох аргачлал зэрэгт өөрчлөлт оруулсан ба мөн хөшүүргийн үзүүлэлтийг нэмж оруулсан байдаг.

⁴ 1974 онд G10 Швейцарын BIS банкны ивээл дор байгуулсан байгууллага

⁵ BAZEL IV-ийг боловсруулан гаргасан ба энэ нь банкны тогтвортой байдлын удирдлагыг өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй байдалд үндэслэсэн удирдлагыг шууд хэрэгжүүлж байна.

Хөшүүргийн үзүүлэлтийн харьцааны зохистой хэмжээг 6-8% гэж үзсэн ба 2018 оноос банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг үнэлэхэд ашиглах зөвлөмжийг гаргажээ. Өнөөгийн байдлаар АНУ-ын холбооны нөөцийн банкны гишүүн банкууд хяналт, шалгалтын хүрээнд ашигладаг бол Европын холбооны улсын банкуудын хувьд 2012 онд уг үзүүлэлтийг ашиглах нь зөв гэж үзсэн бөгөөд 2015 оноос хяналт шалгалтанд ашиглаж эхэлсэн байна.


Монгол банк банкуудын дүрмийн санг өсгөх замаар өөрийн хөрөнгийн хэмжээг өсгөх бодлогыг баримталж байгаа ба дүрмийн сангийн доод хэмжээг сүүлийн 10 жилд 3 дахин шинэчлэн тогтоож 2017 оны 12 сарын байдлаар 50 тэрбум төгрөг болгох зохицуулалтыг хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд банкны өөрийн хөрөнгийн бүтэц, өсөлт дараах байдалтай байна.




Өөрийн хөрөнгийн жилийн дундаж өсөлт 44% болж, 2000 онтой харьцуулахад 202 дахин өссөн байна. Эдийн засгийн хямралын үед банкны салбар дахь өөрийн хөрөнгийн өсөлтийн хурд саарах буюу өмнөх жилийн мөн үеийн хэмжээнээс буурах үзэгдэл ажиглагдаж, 2015 оны байдлаар банкны зах зээл дэх өөрийн хөрөнгийн хэмжээ 2.6 их наяд төгрөгт хүрсэн нь хөрөнгө оруулалтын хэмжээ, бизнесийн өгөөжийн түвшин банкны салбарт өндөр байгаа нь өөрийн хөрөнгийн өсөлтийн гол хүчин зүйл болжээ. Эдийн засгийн хямралын жилүүдэд өөрийн хөрөнгийн өсөлтийн хурд саарч, 2009 онд буурсан байна. Хэдийгээр банкны өөрийн хөрөнгийн хэмжээ өссөн боловч өөрийн хөрөнгөөр баталгаажих өр төлбөртэй харьцуулахад өсөлтийн хурд бага байна.

Банкны өөрийн хөрөнгийн өсөлтийн дотоод хүчин зүйлийн хамаарлыг корреляцын аргаар үнэлж үзвэл энгийн хувьцаа нь нийт өөрийн хөрөнгийн өсөлтөд хамгийн чухал нөлөөлөгч хүчин зүйл бөгөөд өөрийн хөрөнгийн өсөлтийн 39.53%-ийг дангаараа тайлбарлаж байгаа бол давуу эрхтэй хувьцаа, халаасны хувьцаа, нэмж төлөгдсөн капитал, ашиг зэрэг үзүүлэлтүүд нь эерэг, бусад өмч, нөөцийн сан, хоёрдогч өглөг зэрэг үзүүлэлтүүд өөрийн хөрөнгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Зураг 2. Банкны нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгийн өсөлтийн харьцаа




Зураг 3. Банкны хөшүүргийн үзүүлэлтүүд



2006-2015 оны байдлаар банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 12.43 дахин, нийт хөрөнгийн хэмжээ 13.54 дахин өссөн, өөрийн хөрөнгийн өсөлтийн хурд нийт хөрөнгийнхөөс доогуур байгаа нь нийт хөрөнгийн санхүүжилтэд өөрийн хөрөнгийн оролцоо буурч байгааг харуулж байна. Иймд өөрийн хөрөнгийн оролцоог нэмэгдүүлэх замаар банкуудын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх зохицуулалт шаардлагатай юм.

Банкны дүрмийн сангийн зохицуулалт нь зайлшгүй хүчин зүйл байсан гэдгийг (Зураг 4) судалгааны үр дүнгээс харах боломжтой. Банкуудын өр төлбөрийн өсөлт, өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдаас хоцорсон тухай бүрт Монгол банк банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээг өсгөх зохицуулалтыг хийж иржээ. Судалгаанд хамрагдсан хугацаанд банкны салбарын хөшүүргийн харьцааны дундаж үзүүлэлт 15.1% байгаа бөгөөд

Зураг 4. Банкны салбарын нийт өөрийн хөрөнгө ба үндсэн депозитоор тооцсон хөшүүргийн харьцаа, хэлбэлзэл



салбарын хувьд 2011 оны 4 сард 9.34% болж хамгийн доод түвшиндээ хүрсэн ба 2016 оны 1-р сар хүртэл уг үзүүлэлт өссөн байна.

Базел III хүрээнд санал болгосон хөшүүргийн үзүүлэлтийг тооцоходоо банкны хүлээж болзошгүй өр төлбөрт балансын гадуурх ба дотуурх өр төлбөр, үнэт цаасны үнэлгээ, арилжааны хүлээж болзошгүй өр төлбөр зэргийг хамруулан тооцох тухай заасан бөгөөд энэхүү үзүүлэлтийг ашиглахдаа үзүүлэлтүүдийн харьцааг үе шаттайгаар өсгөх, тухайлбал, 3-8% болгохыг зөвлөсөн болно.

$$K_L = \frac{1\text{-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө}}{\text{Хүлээж болзошгүй өр төлбөр}}$$

МУ-ын банкны салбарын хөшүүргийн үзүүлэлтийг:

K_1 - Нийт өөрийн хөрөнгө ба депозит

K_2 - I зэрэглэлийн өөрийн хөрөнгө ба депозит


K_3 - Энгийн хувьцаа ба цэвэр хадгаламж гэсэн үзүүлэлтүүдээр тус тус тооцоолов.
(Зураг 3)

ОУ-ын туршлагаас үзвэл хөшүүргийг тооцох үзүүлэлтийн сонголтоос хамаарч босго утгыг 8-20% хүртэл хувь хэмжээгээр тогтоон ашиглаж байгаа бөгөөд манайд эдгээр үзүүлэлтүүдийн дундаж утга K_1 –19.29%, K_2 –9.78%, K_3 –14.53% байна (Хавсралт 1).

Банкны I зэрэглэлийн өөрийн хөрөнгөд банкны өрийн хариуцлагыг илэрхийлэх эзний өмчийн зүйлүүд буюу энгийн хувьцаа, халаасны хувьцаа, тухайн жилийн болон өнгөрсөн жилийн ашиг, ашгаас хуваарилагдсан сангууд орж байгаа тул уг хөрөнгө ба нийт депозитын харьцаагаар хөшүүргийн үзүүлэлтийг тооцох нь зохистой юм.

Манай улсын хувьд зах зээлд оролцогчид өөрсдийн илүүдэл нөөцөө санхүүгийн зах зээлд байршуулах сонголт бага, банкны хадгаламжинд хэт төвлөрсөн байдлаар байршуулдаг, банкуудын эх үүсвэрт харилцах хадгаламжийн хэлбэрийн эх үүсвэрийн эзлэх хувь хэмжээ буурч байгаа ч нийт хэмжээ тасралтгүй өсч байгаа тул нийт депозит ба өөрийн хөрөнгийн харьцааг зохистой түвшинд барих нь зүйтэй юм. Банкны өөрийн хөрөнгө хадгаламжийн харьцааг зохистой түвшинд барьснаар хадгаламжийг эрсдэлд орохоос зайлсхийх боломж бүрдэх ба банкууд хадгаламжаас бусад эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллахад хөшүүрэг болох талтай.

Зураг 5. I зэрэглэлийн өөрийн хөрөнгө, депозитын үлдэгдлээр тооцсон хөшүүргийн үзүүлэлт (2006-2015 он, сараар)



Хөшүүргийн үзүүлэлтийг тооцохдоо банкны I зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хамрагдах хөрөнгийн нийлбэрийг нийт харилцах хадгаламжийн үлдэгдэлд харьцуулан тооцох боломжтой юм. Манай улсын хувьд уг үзүүлэлтийн хугацааны дундаж нь 9.78%, 2006-2015 оны дундаж үзүүлэлт 7.5% байна. 2008 оноос эхлэн энэ үзүүлэлт буурч байсан бол 2015 оны эцэст өсөх хандлагатай болжээ (Зураг 5).

Манай улсын банкны салбарын хувьд дампуурлын индекс Z, хөрөнгийн өгөөж ROA, муу зээлийн түвшин NPL үзүүлэлтийг хөшүүргийн үзүүлэлттэй хамаарах хамаарлыг үнэлж үзвэл хөшүүргийн үзүүлэлт, дампуурлын үзүүлэлтүүд шууд хамааралтай, эрсдэл ба өгөөжийн түвшин урвуу хамааралтай байна (Хавсралт 2). Хөшүүргийн үзүүлэлтэнд системийн муу зээл, дампуурал, активын өгөөж үзүүлэлтүүдийн нөлөөллийг дараах тэгшитгэлээр тайлбарлаж болох юм.

$$K = -0.1252 + 0.0046 * Z - 2.1376 * NPL + 1.1647 * ROA (R^2 = 0.7998)$$

Тэгшитгэлээс харахад эдгээр үзүүлэлтүүд хөшүүргийн үзүүлэлттэй сөрөг хамааралтай, харин дампуурлын индекс (Z) нь хөшүүргийн үзүүлэлттэй (K) эерэг хамааралтай ба уг үзүүлэлт нэг хувиар өсөхөд хөшүүргийн үзүүлэлт 0.0046 хувиар өснө, харин хөшүүргийн үзүүлэлт муу зээл (NPL) үзүүлэлттэй урвуу хамааралтай буюу уг үзүүлэлт нэг хувиар өсөхөд хөшүүргийн үзүүлэлт 2.1376 хувиар буурна, хөрөнгийн өгөөж (ROA) гэсэн үзүүлэлтүүдтэй шууд хамааралтай бөгөөд харгалзах үзүүлэлтүүдийг 1%-аар өөрчлөхөд 1.1647 хувиар хөшүүргийн үзүүлэлт өсөхөөр харагдаж байна.

Банкны салбарын хямралын үед харилцагчид банкнаас харилцах хадгаламжаа татдаг нь уг үзүүлэлтэд нөлөөлсөн ба банкны дүрмийн санг өсгөх бодлого нь хямралын үе шатуудтай давхцаж байгаа нь шинжилгээний үр дүнд нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Банкны салбарын хувьд муу зээлийн хэмжээ өсөхийн хирээр банкны алдагдлын хэмжээ өсөж өөрийн хөрөнгийн хэмжээг бууруулдаг, банк өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй нөхцөлд үйл ажиллагаа эрхлэх нь банкны хөрөнгийн өгөөжид эерэг нөлөө үзүүлдэг болохыг уг судалгааны үр дүн харууллаа. Энэ нь хөшүүргийн үзүүлэлтүүд нь банкны хөрөнгийн өгөөж, эрсдэл, дампуурах магадлал зэрэг үзүүлэлтэд зохих нөлөөллийг үзүүлдэг судалгааны ач холбогдол бүхий үзүүлэлт гэдгийг судалгаа харуулж байна.

Дүгнэлт

1. Банкны салбар дахь өр төлбөрийн өсөлт, түүний дотор харилцах, хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ өсч байгаа энэ үед иргэдийн мөнгөн хадгаламжийг эрсдэлээс хамгаалахын тулд хөшүүргийн үзүүлэлтийг ашиглах нь зүйтэй юм.
2. Банкны салбар дахь өр төлбөр ба өөрийн хөрөнгийн харьцаа сүүлийн жилүүдэд сайжирч байгаа нь банкны дүрмийн сангийн өсөлттэй холбоотой бөгөөд цаашид өөрийн хөрөнгийн өсөлт удаашрах магадлалтай ба түүнээс улбаалан өөрийн хөрөнгө, өр төлбөрийн харьцаа буурч болзошгүй бөгөөд энэ нь банкны хадгаламжаас хараат байдлыг нэмэгдүүлэх талтай юм.
3. Банкны системийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтэд хөшүүргийн үзүүлэлтийг багтааж хэрэглэгчдэд мэдээлэл өгөх нь бусад үзүүлэлтээс илүүтэй ойлгомжтой

бөгөөд банкны санхүүгийн байдлын талаар анхдагч мэдээлэл болох юм.

Уг үзүүлэлт нь бусад бизнесийн байгууллагуудад ашиглагддаг санхүүгийн тогтвортой байдлын үндсэн үзүүлэлтүүдийн нэг тул энгийн ойлгомжтой, тодорхойлоход хялбар, хэрэглээнд нэврүүлэхэд хүндрэлгүй гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Kool, C. (2006). An Analysis of Financial Stability Indicators in European Banking: The Role of Common Factors, *Utrecht School of Economics, Tjalling C. Koopmans Research Institute, Discussion Paper Series 06-12*
2. Cheang, N., Choy, I. (2010). Aggregate Financial Stability Index for an Early Warning System, *Research and Statistics Department, Monetary Authority of Macao*
3. Goodhart, C. A. E., Tsomocos, D. P. (2007). Analysis of Financial Stability, *Special Paper 173, LSE Financial Markets Group Paper Series*
4. Олюнин, Д. Ю. (2009). Методы оценки финансовой устойчивости коммерческого банка, *Автореферат*
5. www.mongolbank.mn - Банкны системийн санхүүгийн тайлан

Хавсралт 1. Салбарын тогтвортой байдлын зарим үзүүлэлтүүдийн статистик

Үзүүлэлтүүд	Өгөгдлийн тоо	Дундаж	Хамгийн их	Хамгийн бага	Ст. хазайлт
Өөрийн хөрөнгө / Депозит	192	19.29%	32.16%	2.26%	5.56%
I зэрэглэлийн өөрийн хөрөнгө / Депозит	192	9.78%	18.20%	4.06%	4.10%
Энгийн хувьцаа / Хадгаламж	192	14.53%	26.11%	6.09%	6.26%
ROA	192	0.18%	1.67%	-1.19%	0.29%
NPL	192	2.74%	16.80%	0.36%	3.79%
Z	192	42.19	58.88	4.20	9.87

Хавсралт 2. Банкны салбарын тогтвортой байдалд хөшүүргийн үзүүлэлтийн үзүүлэх нөлөөлөл

	Коэф.	Ст.алдаа	t стат.	P-утга	Регрессийн статистик	
					Тохируулагдсан R ²	Түүврийн тоо
Сул гишүүн	-0.1252	0.0085	-14.70	0.000	0.7967	192
Z	0.0046	0.0002	25.55	0.000	F статистик	250.51
NPL	-2.1376	0.4887	-4.37	0.000	F-ийн ач холбогдол	0.000
ROA	1.1647	0.0487	23.90	0.000		